



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв  
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.10.04 № 01/2042  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ  
ЭТГЭЭДҮҮДЭД**

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан  
ЭТТХК/20240103471 дугаартай “Катеринг, кемп  
түрээсийн үйлчилгээ (энтц)” үзүүлэгчийг сонгох  
тендер шалгаруулалтад тендерт оролцохыг  
сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг  
хавсралтаар хүргүүлж байна.

Дээрх тодруулга нь тендерийн баримт бичгийн  
салшгүй нэг хэсэг болно.

Хавсралт: 01 хуудас.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ

1124051148



Тодруулгын хариу

Тендерийн нэр	“Катеринг, кемп түрээсийн үйлчилгээ (энтц)” үзүүлэгчийг сонгох
Тендерийн дугаар	ЭТТХК/20240103471
Тендер зарласан огноо	2024 оны 09 дүгээр сарын 10
Тендер нээх огноо	2024 оны 10 дугаар сарын 09
<b>Тодруулга №1</b>	
<b>Тодруулга</b>	<b>Хариу</b>
<p>Кемп, катеринг түрээсийн үйлчилгээний техникийн тодорхойлолтын:</p> <p>"1. Өмнөговь аймгийн Ханбогд сум Хайрхан багт байрлах Чингэлэгт тээврийн терминал төвөөс 20 хүртэлх км зайд кемп, катерингийн үйлчилгээ үзүүлнэ." гэж заасан байна. Яг тухайн байршилд 125 ажилтан байрлах кемп байгуулах юм уу, эсвэл бусад компанийн одоо байгаа кемптэй харилцан гэрээ байгуулах юм уу? Үгүй бол тогтоосон байршил дахь ажилчдад зөвхөн өдөр, шөнийн хоолоор үйлчлээд ажилчдын амрах кемп нь бусад байршилд байж болох юм уу.</p>	<p style="text-align: center;">Техникийн тодорхойлолтын</p> <p>1.1 Чингэлэгт тээврийн терминал төвөөс 20 хүртэлх километр зайд кемп, катерингийн үйлчилгээг нэг цэгт үзүүлнэ,</p> <p>1.3 Хоногт 125 хүртэлх хүн байрлуулах кемп, катерингийн үйлчилгээ үзүүлэх өөрийн эзэмшлийн болон түрээсийн барилга байгууламжтай байх гэж заасан.</p>
<b>Тодруулга №2</b>	
<b>Тодруулга</b>	<b>Хариу</b>
<p>1. Нэг ээлжид ажиллах нийт ажилчдын тоо,</p> <p>2. ЭНТЦ гаалийн бүсэд хүргэлтээр авах өдөр, шөнийн хоолны тоо болон хүний тоо,</p> <p>3. Нэг ээлжид кемпэд байрлах ажилчдын тоо,</p>	<p>1. Нэг ээлжид ажиллах нийт ажилчдын тоо 125 хүртэлх хүн байна. /өдөр шөнийн ээлжид ажиллах нийт хүн/</p> <p>2. Өдрийн ээлжийн 80 ажилтан, шөнийн ээлжийн 45 ажилтанд техник тодорхойлолтод заасны дагуу заалаар болон заасан цэгүүдэд хоол хүргэлт хийгдэнэ.</p> <p>3. Техникийн тодорхойлолтод заасны дагуу хоногт 125 хүртэлх хүн байрлана.</p>